



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/002/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

᠒᠐᠒5.01.24 № ᠒᠒᠑

танай ᠒᠐᠒5.01.24-ны № 4 -т

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
2 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ц.САРАНЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант жилд нийгмийн даатгалын систем шинэчлэгдэж, төрийн алба хаагчдын цалингийн нэгдсэн системд ажил мэргэжлийн код болон даатгуулагчийн кодыг зөрүүтэй оруулснаас ажилтнаас илүү дутуу шимтгэл суутгах, байгууллагаас төлөх шимтгэлийн хэмжээг илүү дутуу тооцоолсноос шалтгаалан жилийн эцэст авлага, өр төлбөр үүсэж тайланд залруулгууд хийгдсэн байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

011022051

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилго, 8 зорилт, 71 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Боловсролын газраас 92.0 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	252,563,785.15	507,377,918.75
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	83,322,019.19	302,617,005.60
312	Банканд байгаа бэлэн мөнгө	83,322,019.19	302,617,005.60
3121	Төгрөг	83,322,019.19	302,617,005.60
312113	Төрийн сангийн харилцах	83,322,019.19	302,617,005.60
33	АВЛАГА	-	639,221.85
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	450,124.80
335	Бусад авлага	-	189,097.05
3351	Байгууллагаас авах авлага	-	189,097.05
35	БАРАА МАТЕРИАЛ	169,241,765.96	204,121,691.30
354	Хангамжийн материал	169,241,765.96	204,121,691.30
35470	Бусад хангамжийн материал	169,241,765.96	204,121,691.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,513,922,306.37	2,591,828,566.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,513,922,306.37	2,591,828,566.26
392	Биет хөрөнгө	1,892,662,306.37	1,970,568,566.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,056,382,308.44	2,115,904,245.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	(281,277,248.60)	(315,106,873.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	103,858,833.40	101,247,352.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	(49,933,722.84)	(38,753,655.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	71,069,973.80	71,324,973.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,462,863.14)	(40,162,728.30)
39214	Бусад үндсэн хөрөнгө	43,399,400.00	93,899,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(18,720,102.19)	(21,396,520.19)
39217	Номын фонд	3,345,727.50	3,612,372.50
393	Биет бус хөрөнгө	621,260,000.00	621,260,000.00
39301	Програм хангамж	1,122,000.00	1,122,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,122,000.00)	(1,122,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	621,260,000.00	621,260,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,766,486,091.52	3,099,206,485.01
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,766,486,091.52	3,099,206,485.01
51	Засгийн газрын хувь оролцоо	2,766,486,091.52	3,099,206,485.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,034,857,771.64	1,034,857,771.64
51101	Өмч: - төрийн	1,034,857,771.64	1,034,857,771.64
512	Хуримтлагдсан үр дүн	896,169,013.08	1,228,889,406.57
51210	Өмнөх үеийн үр дүн	896,169,013.08	896,169,013.08
51220	Тайлант үеийн үр дүн		332,720,393.49
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	835,459,306.80	835,459,306.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,766,486,091.52	3,099,206,485.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,226,133,299.38	1,695,353,834.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	158,412,899.38	174,391,034.35
120	Нийтлэг татварын бус орлого	158,412,899.38	174,391,034.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,815,344.00	7,037,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,626,000.00	3,395,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	1,189,344.00	3,642,100.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	139,231,057.50	131,781,690.65
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	14,366,497.88	35,571,743.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,067,720,400.00	1,520,962,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,007,204,500.00	1,466,902,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,007,204,500.00	1,466,902,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,618,000.00	400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,618,000.00	400,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	57,897,900.00	53,660,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/	57,897,900.00	53,660,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,052,175,251.43	1,362,633,440.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,052,175,251.43	1,362,633,440.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,004,027,822.63	1,314,272,064.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	734,697,542.06	983,911,469.28
210101	Үндсэн цалин	538,430,774.47	681,902,945.28
210102	Нэмэгдэл	175,109,395.59	266,782,854.00
210104	Урамшуулал	21,157,372.00	35,225,670.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,202,442.78	117,621,107.54
210201	Тэтгэврийн даатгал	62,906,762.47	80,918,078.59
210202	Тэтгэмжийн даатгал	7,423,071.53	9,789,918.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,024,587.43	4,945,875.96
210204	Ажилгүйдлийн даатгал	1,336,045.97	4,414,608.74
210205	Эрүүл мэндийн даатгал	13,511,975.38	17,552,625.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,882,035.70	47,471,343.92
210301	Гэрэл, цахилгаан	14,085,565.68	16,392,298.73
210302	Түлш, халаалт	19,692,824.02	20,832,359.19
210303	Цэвэр, бохир ус	9,103,646.00	10,246,686.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,034,340.00	16,530,318.36
210401	Бичиг хэрэг	743,700.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,290,640.00	-
210408	Бараа материал акталсны зардал	-	16,530,318.36
2105	Нормативд зардал	39,088,320.40	32,490,486.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	48,450.00	-
210502	Хоол, хүнс	39,039,870.40	32,490,486.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,044,494.00	19,424,245.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,626,000.00	3,395,500.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	5,418,494.00	16,028,745.92

Дорнод аймгийн Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,578,647.69	93,823,093.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,421,448.35	29,034,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,347,630.00	10,913,413.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,809,569.34	53,875,430.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,147,428.80	48,361,376.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,631,564.50	45,172,320.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,631,564.50	45,172,320.00
2134	Орон нутгийн төвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт	12,515,864.30	3,189,056.08
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,515,864.30	3,189,056.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	173,958,047.95	332,720,393.49
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (5)	426,799.76	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	426,799.76	-
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (6=4-5)	(426,799.76)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	173,531,248.19	332,720,393.49

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,072,535,744.00	1,528,000,400.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,072,535,744.00	1,528,000,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,441,344.00	7,037,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,815,344.00	7,037,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,815,344.00	7,037,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,626,000.00	3,395,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	1,189,344.00	3,642,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,067,720,400.00	1,520,962,800.00
	Улсын төвлөрсөн төсвөөс	1,007,204,500.00	1,466,902,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,007,204,500.00	1,466,902,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,618,000.00	400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,618,000.00	400,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	57,897,900.00	53,660,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	57,897,900.00	53,660,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,022,280,803.74	1,308,705,413.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,022,280,803.74	1,308,705,413.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	968,188,824.44	1,260,344,037.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	734,697,542.06	984,550,691.13
210101	Үндсэн цалин	538,430,774.47	682,542,167.13
210102	Нэмэгдэл	175,109,395.59	266,782,854.00
210103	Урамшуулал	21,157,372.00	35,225,670.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,202,442.78	117,621,107.54
210201	Тэтгэврийн даатгал	62,906,762.47	80,918,078.59
210202	Тэтгэмжийн даатгал	7,423,071.53	9,789,918.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,024,587.43	4,945,875.96
210204	Ажилгүйдлийн даатгал	1,336,045.97	4,414,608.74
210205	Эрүүл мэндийн даатгал	13,511,975.38	17,552,625.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,882,035.70	47,471,343.92
210301	Гэрэл, цахилгаан	14,085,565.68	16,392,298.73
210302	Түлш, халаалт	19,692,824.02	20,832,359.19

Дорнод аймгийн Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	9,103,646.00	10,246,686.00
2105	Нормативд зардал	33,095,319.90	32,490,486.00
210502	Хоол хүнс	33,095,319.90	32,490,486.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,060,041.00	19,424,245.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,626,000.00	3,395,500.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	5,434,041.00	16,028,745.92
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,751,443.00	55,786,163.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,403,813.00	44,872,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,347,630.00	10,913,413.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,091,979.30	48,361,376.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,576,115.00	45,172,320.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,576,115.00	45,172,320.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,515,864.30	3,189,056.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,515,864.30	3,189,056.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	50,254,940.26	219,294,986.41
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	50,254,940.26	219,294,986.41
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	33,067,078.93	83,322,019.19
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	83,322,019.19	302,617,005.60

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,034,857,771.64	835,459,306.80	896,169,013.08	2,766,486,091.52
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,034,857,771.64	835,459,306.80	896,169,013.08	2,766,486,091.52
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн			332,720,393.49	332,720,393.49
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,034,857,771.64	835,459,306.80	1,228,889,406.57	3,099,206,485.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	83,322,019.19	(83,322,019.19)
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,556,705,200.00	1,255,045,013.59	301,660,186.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,556,705,200.00	1,255,045,013.59	301,660,186.41

Дорнод аймгийн Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,507,217,800.00	1,209,872,693.59	297,345,106.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,213,253,000.00	984,550,691.13	228,702,308.87
210101	Үндсэн цалин	831,641,700.00	682,542,167.13	149,099,532.87
210102	Нэмэгдэл	370,941,800.00	266,782,854.00	104,158,946.00
210104	Урамшуулал	10,669,500.00	35,225,670.00	(24,556,170.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,500,600.00	117,621,107.54	33,879,492.46
210201	Тэтгэврийн даатгал	103,048,800.00	80,918,078.59	22,130,721.41
210202	Тэтгэмжийн даатгал	12,132,600.00	9,789,918.96	2,342,681.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,987,900.00	4,945,875.96	1,042,024.04
210204	Ажилгүйдлийн даатгал	6,066,200.00	4,414,608.74	1,651,591.26
210205	Эрүүл мэндийн даатгал	24,265,100.00	17,552,625.29	6,712,474.71
2105	Нормативд зардал	40,814,600.00	32,490,486.00	8,324,114.00
210502	Хоол хүнс	40,814,600.00	32,490,486.00	8,324,114.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,240,100.00	19,424,245.92	9,815,854.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,395,500.00	3,395,500.00	-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	25,844,600.00	16,028,745.92	9,815,854.08
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,409,500.00	55,786,163.00	16,623,337.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,495,300.00	44,872,750.00	16,622,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,914,200.00	10,913,413.00	787.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,487,400.00	45,172,320.00	4,315,080.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,487,400.00	45,172,320.00	4,315,080.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	49,487,400.00	45,172,320.00	4,315,080.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,556,861,200.00	1,474,340,000.00	82,521,200.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,466,902,500.00	1,466,902,400.00	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,466,902,500.00	1,466,902,400.00	100.00
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	89,558,700.00	7,037,600.00	82,521,100.00
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,395,500.00	3,395,500.00	
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,642,100.00	3,642,100.00	
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	82,521,100.00		
	Нэмэлт санхүүжилтийн орлого	400,000.00	400,000.00	
	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	400,000.00	400,000.00	

	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	83,322,019.19	(83,322,019.19)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	302,617,005.60	(302,617,005.60)

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	53,660,400.00	50,471,343.92	3,189,056.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	53,660,400.00	50,471,343.92	3,189,056.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,660,400.00	50,471,343.92	3,189,056.08
2103	БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ	50,660,400.00	47,471,343.92	3,189,056.08
210301	Гэрэл, цахилгаан	14,085,600.00	16,392,298.73	(2,306,698.73)
21302	Түлш халаалт	21,407,000.00	20,832,359.19	574,640.81
21303	Цэвэр, бохир ус	15,167,800.00	10,246,686.00	4,921,114.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	53,660,400.00	50,471,343.92	3,189,056.08
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	53,660,400.00	50,471,343.92	3,189,056.08
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,660,400.00	50,471,343.92	3,189,056.08

2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 92.1 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс 92.1 сая төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

2.1 Албан шаардлага

1. Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогчид 150 хувь, няравт 100 хувиар тооцон 3.2 сая төгрөг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 дахь "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчин Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор тогтоосон урамшууллын хэмжээг хэтрүүлэн олгосон, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. НДШ-ийн тайлан, Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн систем дэх код буруу тайлагнаснаас ажилтнаас шимтгэлийг 0.4 сая төгрөгөөр дутуу суутгасан нь Төсвийн ерөнхий ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага журмын 4 дүгээр зүйлийн 4.1.5-д "Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үндэслэн батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулж, төрийн өмч, төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх" заалттай нийцэхгүй санхүүгийн тайлангийн иж бүрэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. Түрээсийн орлогыг дээд шатны байгууллагаас баталсан үнийн тарифаар тооцоогүй 6.9 сая төгрөгийн орлогыг дутуу бүрдүүлсэн нь ТӨБЗГ-ын 2020 оны 49 дүгээр тогтоол "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай" хавсралт дахь үнийн хэмжээг баримтлаагүй нь санхүүгийн тайлангийн нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
4. Тендерээр худалдан авалтын 81.4 сая төгрөгийн гэрээг буруу дүгнэж акт үйлдсэн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 39 дугаар зүйлийн 39.3.2-т "Гэрээний зүйл болон бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл, 48.2.9.энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах", 47 дугаар зүйлийн 47.3-т "Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогч, нярав нар тус бүр 150.0 хувиар тооцон олгосон	1	3,248.5			1	3,248.5						
НДШ-ийн тайлан, Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн систем дэх код буруу тайлагнаснаас ажилтнаас шимтгэлийг дутуу суутгасан	1	450.1			1	450.1						
Түрээсийн орлогыг дээд шатны байгууллагаас баталсан үнийн тарифаар тооцоогүй орлогыг дутуу бүрдүүлсэн	1	6,993.4			1	6,993.4						
Тендерээр худалдан авалтын гэрээг буруу дүгнэж акт үйлдсэн	1	81,445.7			1	81,445.7						
Дүн	4	92,137.7			4	92,137.7						



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 149/19125199

Чойбалсан хот

40А-2025/002/НА-СТА-ТшЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 2 дугаар 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Түрээсийн гэрээний үнэ тооцохдоо жишиг үнийг баримтлаагүй, түрээсийн орлогыг 6,993,400.00 төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т "Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна" Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолын хавсралт "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам"-ын 11-д "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тогтооно" 16-д "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэхдээ түрээсийн төлбөрийн хэмжээг энэ журмын 11-д заасан жишиг үнийг баримтлан, зах зээлийн тухайн үеийн үнэ болон бусад холбогдох үзүүлэлтүүдийг харгалзан тогтоож, гэрээнд тусгана" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.2-т "төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсэн, ашиглуулсны төлбөр болон борлуулсны орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсхүл төвлөрүүлээгүй"; 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, түрээсийн орлогыг тооцохдоо Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолын хавсралт "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам"-ыг мөрдөн ажиллах, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймгийн Төрийн аудитын газарт ирүүлэх.

2125040526

2. Хууль эрх зүйн шийдвэрийг баримтлан ажиллахыг Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн захирал Ц.Саранцэцэг, нягтлан бодогч Э.Ганцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Э.НАНДИНЧИМЭГ

